

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр  
сарын 05 -ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

## Тооллогын комиссын тогтоолыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комисс нь дараах үр дүнг баталсан болохыг дурдсугай.
  - Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 88,25 хувь;
  - Тахько (ХК) компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх санал хураалтын дүнг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,99 хувь зөвшөөрсөн, 0,01 хувь түдгэлзсэн;
  - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн боловсруулсан компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг батлах, санал хураалтын дүнг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,99 хувь зөвшөөрсөн, 0,01 хувь түдгэлзсэн.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

## ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

### Компанийн хэлбэр өөрчлөх төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3, 53 дугаар зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62.1.15, 62.1.16 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тахько (ХК) компани (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсан компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг энэхүү тогтоолын Хавсралт №01-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

# ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

## Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 53 дугаар зүйлийн 53.1.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.4, 62.1.15, 62.1.16 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. “Тахько” оноосон нэртэй хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилснийг баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны бүртгэлээс хасах тухай тогтоол гарах хүртэл хугацаанд үргэлжлүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

# ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

Эрх олгох, зах зээлийн үнэ тогтоох, хувьцааг эргүүлэн худалдаж  
авах ажиллагааг зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.12, 62.1.15, 62.1.16, Санхүүгийн зохицуулах хорооны 225 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах, хувьцааны үнэлгээ хийлгэх, брокерын компани болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай гэрээ байгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Минжмаа/-д олгосугай.
2. Компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбогдуулан Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоож, эсрэг саналтай болон татгалзсан, хуралд оролцоогүй Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл дарга /Л.Буянбат/-д даалгасугай.
3. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй болохыг дурьдаж, хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Минжмаа/-д даалгасугай.
4. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Чулуунтогтох/-д итгэмжилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ